

**МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХЯНАХ, ХАДГАЛАХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ
 ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ХУУДАС**

Д/д	Тайлагнах үйл ажиллагаа	Авбал зохионоо
Нэг. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа		
1.	Тайланд хамрагдах мэдүүлэг гаргагчдын нэрсийн жагсаалтыг үнэн зөв, хугацаанд нь гаргасан байдал/шилжилт хөдөлгөөнийг тухай бүр бүртгэсэн байх/	10
2.	Мэдүүлэг гаргагчдаас мэдүүлгийг хуулийн хугацаанд нь гаргуулж, бүрэн хамруулсан байдал	10
3.	Мэдүүлгийн тайлан мэдээг үнэн зөв, хуулийн хугацаанд, маягтын дагуу ирүүлсэн, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай болон бусад бүртгэлийг бүрэн хөтөлсөн тухай	10
4.	Мэдүүлэг гаргагчдын мэдүүлгийг цахим хэлбэрээр авч бүрэн баталгаажуулсан эсэх	10
5.	“Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програм” дахь “ЭБАТ” цэсний бүртгэлүүдийг тогтмол бүрэн хөтөлсөн эсэх	10
Хоёр. Хяналтын үйл ажиллагаа		
6.	Мэдүүлэг гаргагчдын цаасаар болон цахим хэлбэрээр өгсөн мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьсан байдал	10
7.	Салбар байгууллагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаатай танилцаж, хяналт шалгалтыг явуулсан тухай	10
Гурав. Зөвлөмж болон сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа		
8.	Мэдүүлэг гаргагч болон салбар, нэгжийн эрх бүхий албан тушаалтнуудад сургалт зохион байгуулж, гарын авлага, заавар зөвлөмжөгсөн тухай	10
9.	“Хуулийн хугацаа сануулах” талаар мэдүүлэг гаргагч болон харъяа байгууллагын хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээний тухай /сурталчилгаа болон албан бичиг хүргүүлэх, дотоод сүлжээг ашиглах гэх мэт/	5
10.	Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаар байгууллагын удирдлагаас санаачлан зохион байгуулсан болон Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмж, хариутай бичгийн шийдвэрлэлт, авсан арга хэмжээний тухай	5
Дөрөв. Бусад		
11.	Эрх бүхий албан тушаалтны болон мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд тулгамдаж буй бэрхшээл, түүнийг арилгах арга зам	2
12.	Эрх бүхий албан тушаалтнаас мөрдөн ажиллаж буй хууль тогтоомж, журмыг боловсронгуй болгох санал, хүсэлт	2
13.	Авлигатай тэмцэх газраас эрх бүхий албан тушаалтантай хамтран ажиллах, харилцах асуудлаар санал, дүгнэлт	2
14.	Мэдүүлгийн бүрдүүлэлтийн асуудлаар цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаа, санал санаачлагын тухай	4

❖ Төрийн болон нутгийн захиргааны төв байгууллагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны бичмэл тайланг мэдүүлгийн бүрдүүлэлтийн мэдээ, тайлангийн хамт тухайн оны 3 дугаар сарын 01-ний дотор Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст ирүүлнэ. Тайланд өмнөх оны 03 дугаар сарын 01-нээс тухайн оны 03 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацааны үйл ажиллагааг хамруулж ойлгоно.

❖ Тайланд дээрх хүснэгтэд дурьдсан үзүүлэлт тус бүрээр хийгдсэн ажлаа дэлгэрэнгүй бичиж, тухайн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэр, баримт, материал /батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө, фото зураг, видео бичлэг гэх мэт/-ын хуулбарыг баримтжуулан хавсаргаж ирүүлнэ.

❖ Тайланг 50-иас доош оноо авсан бол “хангалтгүй”, 50-70 оноо авсан бол “дутагдалтай”, 70-90 оноо авсан бол “хангалттай”, 90-100 оноо авсан бол “маш сайн” үнэлгээгээр тус тус дүгнэнэ.